



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 14/61

Нарийнтээл сум


Биеийн тамир, спортыг хөгжүүлэх  
бодлого батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Биеийн тамир, спортыг тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т заасныг үндэслэн ТӨГТООХ нь.

1. Сумын биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогыг хавсралтаар баталсугай.

2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогыг ард иргэдэд сурталчилан хэрэгжүүлж, бүтэн жилээр ИТХ-ын ээлжит хуралдаанд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Сугар), Нийгмийн бодлогын мэргэжилтэн ( Ц.Сайнбилэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА   
Ц.ГАНХУЯГ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023. оны 10 дугаар сарын 05-ны өдрийн  
зэлжит 14.р хуралдааны 01. тогтоолын  
хавсралт

## СУМЫН “БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО”

### Нэг. Нийтлэг үндэслэл:

Техник, технологийн хөгжилтэй холбоотойгоор суурин иргэншил давамгайлах болж, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдж, хүний идэвхтэй хөдөлгөөнийг хязгаарлах, хөдөлгөөний хомсдолтой холбоотой өвчлөл, дэлгэцийн дондолтийн хэт хамаарал нэмэгдэхэд хүргэж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, бодлогын бичиг баримтад идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр булийг дэмжиж, биеийн тамир, спортын эзлтэй орчныг бурдүүлэх зорилтын хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон орон даяар өрнүүлэх, хүн амын ажил, амьдралын салшгүй хэсэг болгох, улмаар Монгол хүний дундаж наслалтыг уртасгах зорилтыг дэвшиүүлсэн байна.

Иймд сумын хэмжээнд биеийн тамир, спортыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарснаар сумын “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого”-ыг боловсруулан хүргүүлж байна.

Монгол улсын төр Засгаас онцгойлон анхаарч жил бүр Монгол орон даяар үндэсний их баяр наадам, 4 жилд 1 удаа Үндэсний спортын их наадам, аймгийн хэмжээнд 2 жил тутамд “Иргэдийн спортын арга хэмжээ”, “Миний нутаг сайхан” спортын наадмыг зохион явуулснаар биеийн тамир спортоор хичээллэгсдийн хувь өсөж байна.

Тус сум нь 2022 онд аймагт зохион байгуулагдсан үндэсний спортын 7 дугаар их наадамд амжилттай оролцож “Тэргүүн” байр, “Миний нутаг сайхан” спортын наадмын зарим төрөлд шагналт байранд шалгарсан амжилт үзүүлсэн билээ. Иймд нийтийн биеийн тамир, спортыг ялангуяа үндэсний спортыг сум орон нутагтаа хөгжүүлж хүүхэд, өсвөр үе, залуучууд, ард иргэдийн спортоор хичээллэх нөхцлийг бурдүүлж, өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, өвлүүлэхэд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Аймаг, улсын тэмцээнд оролцож буй тамирчдын үзүүлж байгаа амжилт нь тухайн сумынхаа нэр хүндийг өндөрт өргөж, хөгжлийн түвшинг илэрхийлэн сурталчлахад онцгой ач холбогдол өгдөг билээ. Тус sumaас үндэсний спортын төрлүүдээр төрөн гарсан олон алдартнуудаар бахарахгүй байхын аргагүй. Тухайлбал: Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат Тамирчин, даяар дурсагдах далай даян дархан аварга Дашдоржийн Цэрэнтогтох, Монгол улсын начин Доржжанцангийн Батмөнх, Монгол Улсын харцага Чогжинмүнсэлийн Даваадорж, Монгол улсын гавьяат тамирчин Д.Төмөрхүлэг, Монгол улсын Начин Б.Лхагвадорж, Монгол улсын Даян мэргэн Б.Пүнсалдулам /сур харваа/, нарын спортын алдартнууд төрөн гарсан билээ. Мөн шинээр хөгжиж буй гар барилдааны 3 удаагийн улсын аварга Г.Мөнх-Эрдэнэ, модон барилдааны Улсын аварга, Азийн

аваргын мөнгөн медальт Т.Адъяатөмөр, сонсголын бэрхшээлтэй иргэдийн залуучуудын дэлхийн аварга Н.Бат-Эрдэнэ, Шагайн харвааны улсын даян мэргэн харваач Довчинбазар, С.Батдорж тамирчид төрөн гарч байна.

Сүүлийн жилүүдэд сумын ИТХ, ЗДТГ-аас биеийн тамир, спорт, тэр дундаа үндэсний спортыг хөгжүүлэхэд илүү анхаарч уралдаан тэмцээн зохион байгуулж, тамирчдад дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна. Сум болон Баянтээг багт 2 спорт заал шинээр байгуулагдснаар өсвөр үе, залуучууд, иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлж байна.

Цаашид биеийн тамир, спортоор дамжуулан хүн амын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, спортын холбоо, спорт хамтлагын ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллагын оролцоог дэмжих, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд оруулж хөгжүүлэх шаардлага гарч байна.

**Хоёр:Алсын хараа:**

Биеийн тамир, спортыг хүн амын хэрэгцээ, онцлогт нийцүүлэн хөгжүүлэх, оюуны болон бие бялдрын өв тэгш хөгжилтэй, хөдөлмөрийн бүтээмж сайтай, бусдыг хүндэтгэгч иргэн болгон төлөвшүүлнэ.

**Гурав:Бодлогын зорилго:**

Биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгох, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхийн түвшинд хүргэх, хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

**Дөрөв:Бодлогын баримтлах зарчим :**

4.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

4.1.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх:

4.1.2. Нутгийн онцлог боломжинд тулгуурлан иргэдэд биеийн тамир, бие бялдрынхүүжил, боловсрол олгох үйл явцыг тасралтгүй, залгамж шинжтэй хөгжүүлэх.

4.1.3. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа нь хорт муу зуршил, хууль бусад асуудлаас ангид байлгах

**Тав. Бодлогыг хэрэгжүүлэх зорилт**

**Зорилт-1: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох:**

5.1.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын, уялдаа холбоог сайжруулах

тах, дасуулж, ортыг хөгжүүлэх чадварын  
ийнд өрсөлдөхүйц чадварын  
илрүүлэх, олноор нь хамруулж,  
ыг хөгжүүлэх, тэмцээн зохион  
доог дэмжих;  
тдэг тамирчдын залгамж халаа  
галт, дасгалжуулалтад дэмжлэг  
зэнд амжилттай оролцон медаль  
тавцанд гаргасан тамирчин,  
ийн чиглэлээр ажиллаж байгаа  
, чадварыг дээшлүүлэх, дэмжин  
ийх талаар мэдээлэл түгээх.

Ибарт төрийн ба төрийн бус  
ын ажиллагаа сайжруулах.  
спортын холбоод, аж ахуйн нэгж  
сад байгууллагын ажлын уялдаа  
длогыг хэрэгжүүлэх;  
исын болон дотоодын төсөл,  
спортын материаллаг баазыг  
идүүлэх;

5.1.2. Иргэдийн бие бялдын түвшин тогтоох сорилыг жилд 2 удаа авч, үр дүнг тооцож хэрэгжүүлнэ

5.1.3. Хүүхэд, залуучуудын бие бялдын хөгжил, соёлыг дээшлүүлэх, тэднийг биеийн тамирын хичээл, секц, дугуйланд тогтмол, тасралтгүй хамрагдан хичээллэх үндсэн нөхцөл болсон заал, танхим, хэрэглэл, материал, техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.1.4.Хүн амын бүлэг, нас, ажил, амьдралын онцлог зэрэгт нийцсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэхийг дэмжих, иргэдийг амралт, чөлөөт цагаараа ажлын байр болон амьдрах орчиндоо биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтээр хичээллэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

5.1.5. Хүн ам, ялангуяа хөдөлгөөний хомсдолтой иргэд, ахмад настны дунд биеийн тамир, дасгал, хөдөлгөөнөөр хичээллэх явдлыг дэлгэрүүлэх, чийрэгжүүлэх техник хэрэгсэл, тоноглолын хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах;

5.1.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах;

5.1.7. Орон нутагт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах;

5.1.8. Орон нутагтаа биеийн тамирын орон тооны арга зүйчтэй болох.

**Зорилт-2. Тамирчдын ур чадварыг ахиулах, дасгалжуулалт, сургалт, тэмцээний шаталсан тогтолцоог бүрдүүлж, спортыг хөгжүүлэх, тамирчдыг аймаг, улс, олимп, тивийн наадам, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвартай болгох**

5.2.1.хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлэх, олонор нь хамруулж, хамт олонч хүмүүжил төлөвшүүлж, багийн спортыг хөгжүүлэх, тэмцээн зохион байгуулах, хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, оролцоог дэмжих;

5.2.2. спортын холбоо, клубийг дэмжиж, шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх холбоодын болон өсвөрийн тамирчдын сургалт, дасгалжуулалтад дэмжлэг үзүүлэх;

5.2.3. олимп, тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцон медаль хүртэж, эх орныхоо нэрийг олон улсын тавцанд гаргасан тамирчин, дасгалжуулагчдыг урамшуулан дэмжих;

5.2.4.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажиллаж байгаа ажилтан, арга зүйч, багш, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх,дэмжин урамшуулах, түгээх,

5.2.5. Иргэдэд сэргээш, допинг хэрэглэхгүй байх талаар мэдээлэл түгээх.

**Зорилт-3. Биеийн тамир, спортын салбарт төрийн ба төрийн бус байгууллага, түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагаа сайжруулах.**

5.3.1. төрийн захиргааны байгууллага нь спортын холбоод, аж ахуйн нэгж байгууллагын биеийн тамир, спортын хамтлаг бусад байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, биеийн тамир, спортын төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

5.3.2.гадаад улсын тусламж, олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

5.3.3. Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, биеийн тамир, спортыг дэмжигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд дэмжклэг үзүүлэх, шинээр спортын хамтлаг байгуулж, жил бүр спорт хамтлагийг шалгаруулж урамшуулах;

5.3.4. Биеийн тамир, спортын материаллаг баазыг нэмэгдүүлэх замаар иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэн спортын заал, танхимын ашиглалтыг сайжруулах, эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлыг хангах.

**Зүргаа: Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:**

Нийтийн биеийн тамир, спортын бодлогыг хэрэгжүүлэхдээ:

- A. Үндэсний спорт
- B. Олимпын болон олимпын бус спорт
- C. Оюуны спорт чиглэлийг баримтлана

**Үндэсний спортын чиглэлээр:**

**6.1. Үндэсний спортыг хүн амын дунд хөгжих таатай орчин бүрдүүлэн, материалаг баазыг бэхжүүлнэ.**

6.1.1. Сургууль, хүүхдийн амралтынүед спортын секц дугуйлан хичээллүүлж, суррагчдыг өргөнөөр татан оролцуулах;

6.1.2. Олимп судлалын танхимтай болж үндэсний спортын танин мэдэхүйн сурталчилгаа самбар, спортын төрөл бүр дээр хийж, сургалт сурталчилгаа зохион байгуулах;

6.1.3. Цахим орчин, Орон нутгийн хэвлэл, мэдээлэлийн хэрэгслэлээр биеийн тамир, спортын сурталчилгааг тогтмол хийх;

6.1.4. Биеийн тамир, спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх, төр, олон нийтийн байгууллагын саналыг дэмжиж ажиллах.

**Хүрэх үр дүн:**

- Үндэсний спортын төрлүүд хөгжих таатай орчин бүрдэж, уралдаан тэмцээний тоо нэмэгдэж, спортоор хичээллэгсдийн болон тэмцээнд оролцогчдын хүрээ өргөснө.

**6.2. Биеийн тамир, спортын уламжлалт заншил, зан үйлийг сэргээн, сонирхогчдын хүрээг өргөжүүлнэ.**

6.2.1 БТС-ын дээд байгууллага, үндэсний спортын улсын холбоодоос үндэсний спортын соёл зан үйл, техник арга барилын талаар гаргасан сургалт сурталчилгааны материал, гарын авлага, CD, DVD бичлэгийг түгээх;

6.2.2 Үндэсний их баяр наадам, цагаан сар, ахмадын өдрөөр ахмад болон залуу үеийг оролцуулсан үндэсний спортын танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн цахим орчинд түгээх;

6.2.3 Спортын арга зүйч, багш дасгалжуулагч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар онцгой анхаарч Биеийн тамир спортын улсын хороо, Монголын Үндэсний Олимпын хороо, аймгийн Биеийн тамир, спортын газар, улсын спортын холбоодоос зохион байгуулсан сургалт семинаарт өргөнөөр хамруулан оролцуулах;

6.2.4 Бөхийн болон хурдан морины цоллооч, шагай харвааны уухайн залгамж халааг бэлтгэхэд анхаарч ажиллах, уралдаан тэмцээн зохион байгуулах;

6.2.5 Уламжлалт үндэсний спортын морь, бөх, сур, шагайн төрлүүд /шагайн харваа, ширээний шагай-шагай шүүрэх, няслах, морь уралдуулах г.м/, шинээр хөгжиж буй жороо морины уралдаан, уургач, бугуйлч, эмнэг сургагчдын тэмцээн зэргийг орон нутгийн онцлог боломжинд тулгуурлан тасралтгүй залгамж шинжтэй хөгжүүлэх.

Хүрэх үр дүн:

- Үндэсний спортын талаарх ард иргэдийн мэдлэг хандлага дээшилж, хичээллэгсдийн хүрээ өргөжинэ.

- Үндэсний спортын төрлүүд аймаг, улсад зохион байгуулагдаж буй тэмцээнд амжилттай оролцох нөхцөл бүрдүүлнэ.

- Үндэсний спортоор хичээллэгчдийн судалгаа, тоон мэдээлэлтэй болно.

### **6.3. Олимпын болон олимпын бус спортын төрлөөр:**

6.3.1. Олимпын спортын төрөл болох жудо, чөлөөт бөх, хүндийн өргөлт, хөнгөн атлетик, волейбол, тенис, дугуйн спорт, сагсан бөмбөг, хөл бөмбөг спортоор өсвөрийн баг тамирчдыг бэлтгэх;

- Олимпын бус спорт болох олс таталт, бүжгийн спорт, аэробик, пауэрлифтинг, сумо бөхийн спортыг хөгжүүлэх;

- оюуны спортын шатар, даам, дартсын төрлүүдээр дугуйлан, секц хичээллүүлэх, хөгжүүлэх, дасгалжуулагч багшийг урьж оролцуулах, дасгалжуулагчийг орон тоогоор ажиллуулах.

6.3.2. Сургууль, хүүхдийн амралтын үед спортын секц дугуйлан хичээллүүлж, сургагчдыг өргөнөөр татан оролцуулах

6.3.3. Үндэсний болон багийн спортыг дэмжиж, олон улсын жишигт нийцсэн гадна талбайн үйл ажиллагааг тогтмолжуулах,

6.3.4 Иргэдийн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж сургуулийн заал, соёлын төвийн заал, танхимыг тусгай нөхцлөөр ашиглуулах,

6.3.5. Жил бүр өсвөр үе, насанд хүрэгчдийн сумын аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулж, спортын холбоод болон аймаг, бүсийн чанартай тэмцээнд оролцох тамирчдыг бэлтгэх, дэмжих.

6.3.6. Фитнес клубүүдийг байгуулж, техник,тоног төхөөрөмж, байраар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх , хичээллэх боломжийг бүрдүүлэх.

6.3.7.Спортын мэдээллийн цахим санг бүрдүүлэх, баяжуулах, шуурхай, бодитой байх зарчмыг ханган мэдээлэл тогтмол оруулах.

6.3.8.Монголын бүх ард түмний спортын их наадам, үндэсний спортын их наадам, хүүхдийн спортын их наадмуудын анхан шатны тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, иргэдэд сурталчлах

6.3.9. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн:

- Биеийн тамир, спортын төрлүүд хөгжих таатай орчин бүрдэж, уралдаан тэмцээний тоо нэмэгдэж, спортоор хичээллэгсдийн болон тэмцээнд оролцогчдын тоо нэмэгдэнэ.

- Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөл бүрдүүлж техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Аймаг, улс, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвар бүхий тамирчинг бэлтгэж, дэмжин ажиллана
- Спорт хөгжих эрх зүйн орчин бүрдэнэ.
- Спортын холбоо, клуб, хамтлагийн үйл ажиллагаа идэвхжинэ
- Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломж бүрдэнэ

Долоо: Бодлого хэрэгжүүлэх хугацаа:

2023-2028 онд хэрэгжүүлэх бөгөөд дунд хугацааны үнэлгээг 2026 онд хийнэ.

Найм: Санхүүжилтын эх үүсвэр:

Бодлогын эх үүсвэрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 8.1. Улсын болон орон нутгийн төсөв
- 8.2. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусlamж
- 8.3. Бусад эх үүсвэр

Ес: Бодлогын хамрах хурээ

Бодлого нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага, нийт иргэдэд хамаарна.

- 9.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага
- 9.2. Төрийн захиргааны байгууллага
- 9.3. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагууд
- 9.4. Сургууль, цэцэрлэг хүүхдийн байгууллагууд
- 9.5. Эцэг, эх, олон нийт, иргэд

Арав. Удирдлага, зохион байгуулалт

10.1.1. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй спорт холбоо, клуб, спорт хамтлаг, арга зүйчдийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг жил бүр дүгнэж сумын Засаг даргын шагнал олгодог болгох

10.1.2. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт спортыг хөгжүүлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх

10.1.3. Сумын Засаг дарга түүний Тамгын газар "бодлого" хөтөлбөрийг сумын хэмжээнд удирдан зохион байгуулах, хамтын оролцоог хангах, хяналт тавьж ажиллана.

10.1.4. "Бодлого"-ыг хэрэгжүүлэхдээ оролцогч байгууллагуудын ажлын уялдаа холбоо, мэдээллээр хангах, үр дүнг тооцох, бодлогын хэрэгжилтийг тайлagnах асуудлыг сумын ЗДТГазар хариуцан хэрэгжүүлнэ.

10.1.5. Сумын Засаг дарга жил бүр бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлagnана.

---оОо---